



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/113/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 88106992 Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.2 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.20 № 2/45

танай _____ -ны № _____ -г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:\alban bichig\A4.docx

005070308

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is a stylized, cursive script.

Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	65,956,573.81	73,516,399.81
33	АВЛАГА	9,950,000.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	9,950,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	56,006,573.81	73,516,399.81
351	Түүхий эд материал	17,221,350.00	23,786,396.00
35110	Тусгай зориулалттай материал	16,041,850.00	22,420,396.00
35130	Эм боох материал	1,179,500.00	1,366,000.00
354	Хангамжийн материал	38,785,223.81	49,730,003.81
35410	Бичиг хэргийн материал	1,040,000.00	1,066,210.00
35420	Аж ахуйн материал	37,345,223.81	48,663,793.81
35440	Түлш, шатах тослох материал	400,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,467,048,022.99	1,637,797,667.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,467,048,022.99	1,637,797,667.20
392	Биет хөрөнгө	1,424,852,022.99	1,595,601,667.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,359,025,613.99	1,581,697,713.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-132,456,386.17	-186,180,909.97
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,836,434.00	30,836,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2,055,762.28	-8,223,049.12
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	126,941,335.47	180,110,335.47
39206	Хуримтлагдсан элэгдэл	-81,044,104.14	-98,175,259.55
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	141,941,238.46	152,197,238.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	-63,562,615.06	-83,636,892.64
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,336,540.00	9,336,540.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,837,681.28	-3,470,893.44
39217	Ном	38,727,410.00	21,110,410.00
393	Биет бус хөрөнгө	42,196,000.00	42,196,000.00
39301	Программ хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-300,000.00	-300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	42,196,000.00	42,196,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,533,004,596.80	1,711,314,067.01
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	57,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	57,000.00
413	Өглөг	00.00	57,000.00
4136	Бусад өглөг	00.00	57,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	57,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,533,004,596.80	1,711,257,067.01
51	Засгийн газрын хувь оролцоо	1,533,004,596.80	1,711,257,067.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	740,885,577.90	740,885,577.90
51101	Өмч: - төрийн	740,885,577.90	740,885,577.90
512	Хуримтлагдсан үр дүн	-215,356,176.24	224,662,673.97
51210	Өмнөх үеийн үр дүн	-215,356,176.24	46,410,203.76
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	178,252,470.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,007,475,195.14	745,708,815.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,533,004,596.80	1,711,314,067.01

Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	904,258,620.00	1,088,371,407.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,152,390.00	253,575,526.00
120	Нийтлэг татварын бус орлого	53,152,390.00	253,575,526.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	53,152,390.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	53,152,390.00	253,575,526.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	00.00	250,397,980.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		3177546.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	851,106,230.00	834,795,881.76
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	699,162,800.00	686,878,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	699,162,800.00	686,878,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,173,130.00	29,022,603.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,173,130.00	29,022,603.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	121,770,300.00	118,894,878.76
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	121,770,300.00	118,894,878.76
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	923,431,887.22	891,698,057.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	923,431,887.22	891,698,057.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	860,528,822.56	826,403,126.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	528,938,100.00	510,881,362.00
210101	Үндсэн цалин	528,938,100.00	510,881,362.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,416,179.25	65,715,107.92
210201	Тэтгэврийн даатгал	45,301,634.25	45,237,364.92
210202	Тэтгэмжийн даатгал	5,278,636.00	5,119,435.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,222,908.00	4,095,549.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,055,728.00	1,023,887.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,557,273.00	10,238,872.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	112,658,615.09	118,889,317.76
210301	Гэрэл, цахилгаан	3,074,160.09	3,799,669.76
210302	Түлш, халаалт	108,804,455.00	114,310,848.00
210303	Цэвэр, бохир ус	780,000.00	778,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,354,620.00	27,489,950.00
210401	Бичиг хэрэг	1,473,000.00	1,596,290.00
210402	Тээвэр, шатахуун	3,363,570.00	3,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	855,350.00	1,398,280.00
210404	Ном, хэвлэл	00.00	18,447,880.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	670,000.00	1,054,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	992,700.00	1,793,500.00
2105	Нормативт зардал	9,641,331.00	14,431,750.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	906,900.00	4,093,500.00
210502	Хоол, хүнс	7,769,831.00	10,070,250.00

Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	964,600.00	268,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,166,482.96	5,182,130.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	85,500.00	00.00
210604	Урсгал засвар	4,080,982.96	5,182,130.00
2107	Томилолт, зочны зардал	1,026,000.00	304,000.00
210702	Дотоод албан томилолт	1,026,000.00	304,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,065,100.00	1,917,933.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,065,100.00	1,187,933.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	230,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	129,262,394.26	100,012,455.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,798,400.00	960,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,447,000.00	1,322,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	125,016,994.26	97,730,455.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,903,064.66	65,294,931.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,322,450.00	40,706,570.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	686,000.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,670,100.00	14,813,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,373,000.00	24,533,170.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	593,350.00	1,360,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,950,914.91	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,950,784.91	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,629,699.75	24,588,361.08
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,629,699.75	24,588,361.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-19,173,267.22	178,252,470.21
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,658,400.00	00.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	1,658,400.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	1,658,400.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-17,514,867.22	178,252,470.21

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	851,106,230.00	834,795,881.76
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	851,106,230.00	834,795,881.76
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	699,162,800.00	686,878,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,173,130.00	29,022,603.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,173,130.00	29,022,603.00



Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	121,770,300.00	118,894,878.76
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	121,770,300.00	118,894,878.76
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	821,798,930.01	808,242,881.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	821,798,930.01	808,242,881.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	758,802,615.35	742,947,950.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	524,380,347.00	508,411,014.92
210101	Үндсэн цалин	378,268,946.00	382,880,431.92
210102	Нэмэгдэл	88,097,400.00	87,882,350.00
210104	Урамшуулал	58,014,001.00	37,648,233.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,993,932.25	68,778,394.00
210201	Тэтгэврийн даатгал	49,922,610.15	49,418,994.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,283,233.82	4,839,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,176,087.03	3,871,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,046,100.00	968,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,565,901.25	9,679,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	112,854,615.09	117,896,378.76
210301	Гэрэл, цахилгаан	3,074,160.09	3,206,730.76
210302	Түлш, халаалт	109,000,455.00	113,910,848.00
210303	Цэвэр, бохир ус	780,000.00	778,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,249,040.00	8,339,280.00
210401	Бичиг хэрэг	1,704,200.00	655,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,363,570.00	3,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,215,350.00	1,398,280.00
210404	Ном, хэвлэл	00.00	110,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	670,000.00	1,076,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,295,920.00	1,899,400.00
2105	Нормативт зардал	10,136,031.00	14,476,750.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,256,200.00	3,182,500.00
210502	Хоол, хүнс	7,769,831.00	10,070,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,110,000.00	1,224,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,234,700.01	10,618,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,456,000.00	440,000.00
210604	Урсгал засвар	6,778,700.01	10,178,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,026,000.00	304,000.00
210702	Дотоод албан томилолт	1,026,000.00	304,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,325,100.00	5,447,433.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	875,100.00	4,717,433.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	230,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,602,850.00	8,676,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	430,000.00	6,700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,172,850.00	1,976,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,996,314.66	65,294,931.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,415,700.00	40,706,570.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,670,100.00	14,813,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,373,000.00	24,533,170.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,372,600.00	1,360,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,950,914.91	00.00



Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,950,914.91	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,629,699.75	24,588,361.08
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,629,699.75	24,588,361.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	29,307,299.99	26,553,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	29,307,299.99	26,553,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,307,299.99	26,553,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,307,299.99	26,553,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,307,299.99	26,553,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-29,307,299.99	-26,553,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	740,885,577.90	1,007,475,195.14	-215,356,176.24	1,533,004,596.80
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	740,885,577.90	1,007,475,195.14	-215,356,176.24	1,533,004,596.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	261,766,380.00	261,766,380.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	740,885,577.90	1,007,475,195.14	46,410,203.76	1,794,770,976.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-261,766,380.00	00.00	-261,766,380.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	178,252,470.21	178,252,470.21
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	740,885,577.90	745,708,815.14	224,662,673.97	1,711,257,067.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	807,071,400.00	781,184,917.68	25,886,482.320	96.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	807,071,400.00	781,184,917.68	25,886,482.320	96.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	783,552,900.00	765,011,517.68	18,541,382.320	97.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	509,469,100.00	508,411,014.92	1,058,085.080	99.79



Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	383,370,000.00	382,880,431.92	489,568.080	99.87
210102	Нэмэгдэл	88,307,800.00	87,882,350.00	425,450.000	99.52
210104	Урамшуулал	37,791,300.00	37,648,233.00	143,067.000	99.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,778,400.00	68,778,394.00	6.000	100.00
210201	Тэтгэврийн даатгал	49,419,000.00	49,418,994.00	6.000	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,839,800.00	4,839,800.00	0.000	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,871,900.00	3,871,900.00	0.000	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	968,000.00	968,000.00	0.000	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,679,700.00	9,679,700.00	0.000	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,193,000.00	117,896,378.76	1,296,621.240	98.91
210301	Гэрэл, цахилгаан	4,195,800.00	3,206,730.76	989,069.240	76.43
210302	Түлш, халаалт	114,217,200.00	113,910,848.00	306,352.000	99.73
210303	Цэвэр, бохир ус	780,000.00	778,800.00	1,200.000	99.85
2104	Хангамж, бараа материалын зардал	8,883,900.00	8,781,680.00	102,220.000	98.85
210401	Бичиг хэрэг	698,700.00	655,000.00	43,700.000	93.75
210402	Тээвэр, шатахуун	3,200,000.00	3,200,000.00	0.000	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,408,900.00	1,398,280.00	10,620.000	99.25
210404	Ном, хэвлэл	553,700.00	553,000.00	700.000	99.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,120,000.00	1,076,000.00	44,000.000	96.07
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,902,600.00	1,899,400.00	3,200.000	99.83
2105	Нормативт зардал	30,499,100.00	14,476,750.00	16,022,350.000	47.47
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,247,900.00	3,182,500.00	65,400.000	97.99
210502	Хоол, хүнс	26,001,700.00	10,070,250.00	15,931,450.000	38.73
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,249,500.00	1,224,000.00	25,500.000	97.96
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,233,200.00	26,229,300.00	3,900.000	99.99
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,000,000.00	16,000,000.00	0.000	100.00
210604	Урсгал засвар	10,233,200.00	10,229,300.00	3,900.000	99.96
2107	Томилолт, зочны зардал	309,700.00	304,000.00	5,700.000	98.16
210702	Дотоод албан томилолт	309,700.00	304,000.00	5,700.000	98.16
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,008,500.00	958,000.00	50,500.000	94.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	268,500.00	228,000.00	40,500.000	84.92
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	0.000	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	230,000.00	10,000.000	95.83
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19178000.00	19176000.00	2,000.000	99.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,700,000.00	6,700,000.00	0.000	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,478,000.00	12,476,000.00	2,000.000	99.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23518500.00	16173400.00	7,345,100.000	68.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,518,500.00	16,173,400.00	7,345,100.000	68.77
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,154,700.00	14,813,400.00	7,341,300.000	66.86



Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,363,800.00	1,360,000.00	3,800.000	99.72
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	807,071,500.00	781,184,917.68	25,886,582.320	96.79
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	686,878,500.00	662,290,038.92	24,588,461.080	96.42
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	686,878,500.00	662,290,038.92	24,588,461.080	96.42
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	120,193,000.00	118,894,878.76	1,298,121.240	98.92
132001	Орон нутгийн төсвөөс	120,193,000.00	118,894,878.76	1,298,121.240	98.92
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.000	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	45.00	45.00	0.000	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.000	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00	0.000	100.00
620003	Үйлчлэх ажилтан	22.00	22.00	0.000	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	370.00	370.00	0.000	100.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	370.00	370.00	0.000	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	45.00	45.00	0.000	100.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	23.00	23.00	0.000	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	22.00	22.00	0.000	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	30,173,130.00	24,533,170.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	30,173,130.00	24,533,170.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,173,130.00	24533170.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,173,130.00	24,533,170.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,173,130.00	24,533,170.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	30,173,130.00	24533170.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,173,130.00	24,533,170.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,173,130.00	24,533,170.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар



сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 84 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд сургуулийн захирал Г.Насанбаяр нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Г.Батдалай хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, Багш нарын мэргэжлийн чадвар, мэргэжил арга зүй, хичээл төлөвлөлтийг сайжруулснаар сурлагын чанарыг 10 аас дээш хувиар ахиулна” гэсэн зорилготой ажиллаж байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/37 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөж байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 923,431.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,234.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,264.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 6,241.8 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,711,314.0 мянган төгрөг болж өмнөх оноос 178,310.0 мянган төгрөгөөр буюу 10.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	65,956.50	73,516.30	7,559.80
Мөнгөн хөрөнгө	-	-	0.00
Авлага	9,500.00	0.00	-9,500.00
Урьдчилгаа	-	-	0.00
Бараа материал	56,006.50	73,516.30	17,509.80
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,467,048.00	1,637,797.60	170,749.60
Үндсэн хөрөнгө	1,749,304.50	2,017,784.60	268,480.10
Хуримтлагдсан элэгдэл	-282,256.50	-379,987.00	-97,730.50
Нийт хөрөнгө	1,533,004.50	1,711,314.0	178,310.10
Өр төлбөр	0	0	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,533,004.50	1,711,257.00	178,252.50
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,533,004.50	1,711,314.00	178,309.50

Бараа материалын дансны үлдэгдэл 73,516.3 мянган төгрөг болж 17,509.8 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалын үлдэгдэл өмнөх оноос 6,378.5 мянган төгрөг, аж ахуй материал 11,318.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба Дээд шатны төсөв захирагчаас шилжүүлж ирсэн 3,216.0 мянган төгрөгийн биеийн тамирын хичээлийн хэрэгсэл, сурах бичгүүдийг хүлээн авч орлогоор бүртгэсэн нь бараа материал голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,017,784.6 мянган төгрөг болж 268,480.1 мянган төгрөгөөр өссөн нь БСШУ яамнаас шилжиж ирсэн 22,725.8 тоног төхөөрөмж, УТХО-аар хийгдсэн сургуулийн барилгыг их засвар 202,672.1 мянга, халуун усны барилгын засвар 20,000.0 мянга, ОНХС-ын хөрөнгөөр 5,000.0 төсвийн хөрөнгөөр 22,310.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,660.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл авч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271-р тогтоолын 4.1.1-д заасны дагуу холбогдох дансанд бүртгэсэн ба өмнөх оны санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн 9,950.0 мянган төгрөгийн ухаалаг самбарыг тус тус холбогдох дансанд орлогоор бүртгэж 18,420.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,711,257.0 мянган төгрөг болж 178,252.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 178,252.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,136,697.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,136,697.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 365,874.2 мянган төгрөгөөр бууруулж 770,823.2 мянган төгрөгөөр анх батлагдсан ба 2021 оны 12 дугаар сард төсөвт зохицуулалт хийгдэж 807,071.4 мянган төгрөг болж 36,248.2 мянган төгрөг буюу 4.4 хувиар өсөж батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 807,071.4 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 686,878.4 мянга, орон нутгийн төсвөөс 120,793.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 686,878.4 мянга, орон нутгийн төсвөөс 118,894.8 мянга нийт 805,773.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 781,184.9 мянган төгрөгийг зарцуулж, 24,588.4 мянган төгрөг буюу 3.7 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Харин орон нутгийн төсвийн санхүүжилтийг 1,298.1 сая төгрөгөөр батлагдсан төлөвлөгөөнөөс дутуу санхүүжүүлсэн байгаа нь төсвийг гүйцэтгэлтэй нь уялдуулан олгосонтой холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 78,184.9 мянган төгрөг буюу 96.8 хувьтай байгаа нь байр ашиглалттай тогтмол зардлыг 1,298.1 мянга, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 1,058.0 мянга, хүүхдийн хоолны зардал 15,931.4 мянга, үдийн цайны зардал 7,341.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн



бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн Төрийн сан банкин дахь 100031215401 тоот дансанд БСУГ-аас хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 24,533.1 мянга, Тэтгэлэгт хөтөлбөрийн уралдааны шагналын мөнгө 4,300.0 мянга, шалгалтын бичиг хэргийн зардалд 189.4 мянга, нийт 29,022.6 мянган төгрөгийг олгосон бөгөөд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахад олгодог 5 жилийн тэтгэмж урамшууллын зардалд 24,533.1 мянга, бичиг хэргийн зардалд 189.4 мянга, тэтгэлэгт хөтөлбөрийн сургалтын төлбөрт 1,084.0 мянга, төслийн зардалд 3,216.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 53 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 88%-тай гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 891,698.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 31,733.8 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь хангамжийн материал өмнөх оноос буурсан бол бусад зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд



хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд Шилэн дансны нэгдсэн системд нийт 807,071.4 мянган төгрөгийн 151 мэдээлэл байршуулахаас хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс тухай бүр оруулахаас Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ өссөн дүнгээр, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, аван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа,

ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, хөрөнгө оруулалт, тендерийн ерөнхий зэрэг 184,313.9 мянган төгрөгийн мэдээлэл зэрэг 9

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	8	1	2
2	Хагас жил	4	4	4	0	0
3	Улирал бүр	1	4	4	0	0
4	Сар бүр	3	36	35	1	0
5	Тухай бүр	8	96	89	7	0
	Нийт	27	151	140	9	2

мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Урсгал төсвийн зарцуулалт нь гүйцэтгэлээр улсын төсвөөс 686,878.4 мянга, орон нутгийн төсвөөс 120,193.0 мянга нийт 807,071.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 781,184.9 мянган төгрөгийг зарцуулж 24,588.4 мянган төгрөг буюу 3.7 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Мөн орон нутгийн төсвөөс тогтмол зардлын санхүүжилт 120,193.0 мянган төгрөг батлагдаж 118,894.8 мянган төгрөгийн олгож төлөвлөгөөнөөс 1,298.1 мянган төгрөг буюу 1 хувийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Тайлант онд тогтмол зардалд 120,193.0 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 24,038.6 мянган төгрөг байна. Тус онд 1,298.1 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалттай бүрэн нийцэхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 17,092.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 723.1 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 4,187.5 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 12,181.6 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 6 заалт бүхий зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажиллаж хэрэгжилтийн тайланг 2021 оны 06 дүгээр сарын 14-ны өдрийн 53 тоот албан бичгээр ирүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах аяны хүрээнд шалгасан байна.



3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 3,161.9 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс 369.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,792.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлээ.

4.2 Төлбөрийн акт

4.2.1 Багш Б.Өлзиймаагийн 1,541.5 мянган төгрөгийн амралтын мөнгөний цалинг 6-р сар НДХ-т 07-дугаар сард давхардуулан мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 3 “нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Давхардуулан мэдээлсэн 1,541.5 мянган төгрөгийн цалинд ноогдох 369.9 мянган төгрөгийн шимтгэлийг НДШ-ын өглөгөөс суутган тооцож төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Зөвлөмж

4.3.1 Мөнгөн хөрөнгийн 25 харилцагчтай холбоотой 204,765.0 мянган төгрөгийн худалдан авалтын гүйлгээг татварын цахим системд бүртгэгдсэн төлбөрийн баримттай тулгахад 4 харилцагчтай холбоотой 2,792.0 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримтыг харилцагчаас гаргуулан аваагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Цаашид журмын дагуу төлбөрийн баримтыг гаргуулан авч төлбөр тооцоог хийж, тулган баталгаажуулж байх зөвлөмж өгөх

4.3.2 Тайлант онд тогтмол зардалд 120,193.0 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвөөс 1,298.1 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Цаашид Засгийн газрын тогтоол болон дээд шатны байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг мөрдөн ажиллах.

4.3.3 Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл мэдээлбэл зохих 149 мэдээллээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ өссөн дүнгээр, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, аван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, хөрөнгө оруулалт, тендерийн ерөнхий зэрэг 184,313.9 мянган төгрөгийн мэдээлэл зэрэг 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн

Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.4, 6.4.5 дахь хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баацагаан сумын ЕБС	4	3,161.9	0	0	1	369.9	0	0	3	2,792.0

_____оОо_____

